

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

УРТЫН ДУУГАА ӨВЛӨН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТУХАЙ

Монголын ардын уртын дуу бол монгол үндэстний буурал түүх, малчин ахуй, амьдралын гүнээс өөрөө урган гарч, монгол нутгийн байгалийн үзэсгэлэн, монгол хүний уужуу тайван сэтгэлийн зохилдлого, нүүдэлчдийн аж төрөхүй, зан заншлын өвөрмөц уянга болон төгөлдөржиж, цараа тавиун хөг аялгуу, төв эрхэмсэг намба, уран гоё нугалаа, баян чимэг бүхий шуранхай, хөг эгшгийн өвөрмөц онцлогтойн хувьд аливаа ард түмний дуунд үл давдагдах ховор шинж агуулсан ардын дууны урлагийн хосгүй уламжлалт сонгодог өв мөн.

Монгол соёл иргэншлийн онцгой ололт,агуулга, хэлбэр, ая хөг, үг хэллэг, айзам хэм төгөлдрийн хувьд монгол соёлын өвөрмөц ололт болсон уртын дууны баян өв санг хадгалах, төрийн хамгаалалтад байлгах, дээдлэн дэлгэрүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэд иргэдээс удаа дараа гаргасан санал хүсэлтийг дэмжин Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэхь заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1.Монгол ардын уртын дууг залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, дуулах эрдэмд сургаж, бүх нийтээр үндэсний бахархалын зэрэглэлээр дээдлэн дэлгэрүүлж, монгол үндэстэн, монгол хүний нэрийн хуудас, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болгох өргөн олны хөдөлгөөн өрнүүлэхийг нийт ард иргэд, аймаг,нийслэлийн, төрийн болон төрийн бус байгууллга, соёл урлагийн ажилтан, зүтгэлтэн, эцэг эх, багш нарт уриалсугай.

2.Уртын дууг сурвалжлан олох, сурган эзэмшүүлэх, судлан шинжлэх, сурталчлан даяаршуулах цогц асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**